

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 01 дүгээр сарын мэдээлэл

2022.01.24.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

1. Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг угтсан төлөвлөгөөт үйл ажиллагааг сумын ИТХ-ын ажлын албанаас зохион байгуулж, төрийн бүх байгууллага, иргэдийн дунд “Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ?” АХА тэмцээн, 4-5 настай хүүхдүүдийн дунд “Бяцхан хүчтэн” бөхийн барилдаан зохион байгуулж, дүгнэлээ.
2. “Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээ, Алтан Дарь овооны 1000 машины зогсоолд аялагчдаас хураамж авах, сумын Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамж зэрэгт өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоохоор холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлэн Хууль зүйн яаманд бүртгүүлэхээр шийдвэрлэв.
3. “Аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамж, Засгийн газрын 01 дүгээр албан даалгавар, аймгийн ОК-ын хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд сумын Засаг даргын 2022 оны А/05 дугаар захирамжаар “Цар тахлын омикрон хэлбэрийн дэгдэлтийн оргил үед авах арга хэмжээ”-ний талаар шийдвэрлэн, төрийн байгууллагуудын ажлын цагийн хуваарийг батлан, 0-5 настай хүүхэдтэй эцэг эхийг цахимаар ажиллуулж, худалдаа үйлчилгээний цэг салбарт баримтлах халдвар хамгааллын чиглэлээр зөвлөгөө зөвлөмж өгөх, сурталчилгаа хийх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон 2022.01.23-26 ны өдрүүдэд ажиллуулж, цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж гарын авлага 90 ширхэгийг тарааж, хүнсний барааны хадгалалтын хугацаанд хяналт хийж, зөвлөгөө өгөв.
4. Сумын Онцгой комиссын шийдвэр болон Засаг даргын захирамжаар “Тандалтын баг”-ийг шинэчлэн томилж, өдөр бүр мэдээ мэдээллийг нэгтгэн ажиллах үүрэг бүхий Тандалтын багийн жижүүр ажиллуулж, цар тахлын батлагдсан тохиолдлын ойрын хавьтал тогтоож, хяналт тавин аймгийн ЭМГ-т мэдээг хүргүүлж байна.

5. Сумын Иргэдийн Төлөөлөгчид болон ажлын албаныхан Улаанбаатар хотод чадавхжуулах сургалтад хамрагдлаа.
6. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021.12.22 ны өдрийн А/733 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргын 2022.01.10 ны өдрийн А/02 дугаар захирамжаар 2022 оны цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Тамгын газрын даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй томилон , бүртгэл мэдээ тайланг 2022.01.25 ны өдөр аймгийн Цэргийн штабт биечлэн очиж тушаалаа.
7. Сумын 2021 оны үйл ажиллагааны тайланг 2022.01.05 ны өдөр аймгийн ХШҮДоАХ-т Тамгын газрын дарга биечлэн очиж тушаасан.
8. Сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын өргөтгөсөн хурлыг 2022.01.03 ны өдөр зохион байгуулж, тайлант оны мэдээ мэдээллийг өгч, 2022 онд зохион байгуулах ажлын чиглэлээр үүрэгжүүллээ. Үүнд: Сар бүрийн сүүлчийн 7 хоногийн 3 дахь өдрийг “ИРГЭДТЭЙ УУЛЗАХ мэдээллийн өдөр” болгохыг ИТХ-ын ажлын албатай хамтран зохион байгуулна. БЗД нар болон Тамгын газрын 10- тын системийн дарга нар хариуцна.
9. Улирал бүрийн эхний сарын 7 хоногийн 5 дахь өдөр сумын ИТХ-ын ажлын албанд үйл ажиллагааны явцын тайланг өгч байх. Бүх БЗДарга, мэргэжилтэн албан хаагчдын тайланг Тамгын газарт тайланг ирүүлнэ.
10. 2022 оны 01 дүгээр сараас эхлэн мөрдөгдөх шинэчлэгдсэн хуулиудтай уялдуулан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, байгууллагын дотоод дүрэм журманд шинэчлэлт хийхээр шийдвэрлэв.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

1/. Бар жилийн сар шинийн босгон дээр сумаас “Улсын аварга” малчин 1, аймгийн аварга малчин 3, сумын аварга малчин шинээр 10, “Алтан унаганы эзэн”-1, “Алтан хурганы эзэн” 1, сумын “Алдарт уяач” 6 тус тус тодорлоо.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1/. ЕБС: БШУЯ-наас Боловсролын чанарын шинэчлэл төслийн Интерактив хэрэглэгдэхүүн хичээл бүтээх арга зүйн сургалтад 2,693240 (Хоёр сая зургаан зуун ерэн гурван мянга хоёр зуун дөчин) төгрөгийн санхүүжилтээр багш нараа оролцууллаа.

2/. Бүгд Найрамдах Солонгос улсын Соёлын Яамнаас “Баярлалаа-Миний бяцхан номын өргөө”- төслөөс 17,423938 төгрөгийн ном ариутгагч тоног төхөөрөмжийг хүлээн авлаа.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ